



**МОНГОЛЫН СУВИЛАГЧДЫН  
НИЙГЭМЛЭГ**

Ш/х-78, Улаанбаатар-210648,

Энхтайвны гудамж-13В

Утас: 99119733, Факс:

Website: <http://www.owc.org.mn/msn/>

2013.01.30 № 01.  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭМГ, БОЭТ  
ТӨВ ЭМНЭЛЭГ, ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ЗАХИРАЛ, СУВИЛАХУЙН АЛБАНЫ  
ДАРГА НАРТ**

Сувилагч мэргэжлийн зэрэг горилох эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийтлэг болон тусгай шалгуурын дагуу бүрдүүлсэн материалыг тухайн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн болон сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, сувилахуйн албаны дарга нар 2013 оны 02 дугаар сарын 18-аас 02 дугаар сарын 28-ны өдрүүдэд Монголын Сувилагчдын Нийгэмлэгт ирүүлнэ үү.

Хаяг: Монголын Сувилагчдын нийгэмлэгийн байранд МСН-ийн хариуцлагатай нарийн бичгийн дарга Р.Тогтох, харилцах утас 95726372, 93146072  
/Улсын хоёрдугаар төв эмнэлэг, 50 ортын I давхарт /

Жич: 2013 онд зэргийн шалгалтанд орох хүсэлтэй сувилагч мэргэжилтний материалыг бүрдүүлж ирүүлэх тусгай шалгуурыг хавсралтаар хүргүүлэв.

ТЭРГҮҮН



Д.НЯМСҮРЭН

## Хавсралт

Мэргэжлийн зэрэг горилох шалгалт өгөх сувилагч мэргэжилтэнд тавигдах нийтлэг шалгуурыг Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн захирлын 2013.01.22-ны өдрийн 69 тоот албан бичгийн хавсралтанд заасны дагуу бүрдүүлнэ. /Web: [www.chd.moh.mn/](http://www.chd.moh.mn/)

### **Мэргэжлийн зэрэг горилогч сувилагч мэргэжилтнүүдэд тавигдах тусгай шалгуур**

#### **А. Ахлах зэрэг горилогч**

1. Мэргэжлийн ажлаа чадварлаг санаачлагатай гүйцэтгэж ирсэн, сувилахуйн мэргэжлийн тусламж үйлчилгээнд 2-оос доошгүй шинээр нэвтрүүлсэн туршлага бүхий
2. Сувилахуйн тусламж үйлчилгээний стандартыг мөрдлөг болгон, мэргэжлийн дутагдал алдаа дутагдал гаргалгүй ажилласан байх
3. Сувилагч мэргэжилтний ёс зүйг баримтлан ажиллаж ирсэн, байгууллагын соёл, дотоод дэг журам зөрчөөгүй,
4. Хамт ажиллагсад болон өөрийгөө хөгжүүлэх эрмэлзлэл бүхий, дотоод гадаадад мэргэжлийн сургалтанд хамрагдсан, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцсон
5. Мэргэжлийн зэрэг горилж буй хүсэлтийг бичгээр МСН-ийн нэр дээр гаргах
6. Сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн буюу сувилахуйн албанаас дэмжсэн тодорхойлолт

#### **Б. Тэргүүлэх зэрэг горилогч**

1. Мэргэжлийн ахлах зэрэг бүхий,
2. Мэргэжлийн ахлах зэргийн тусгай шалгуур бүрийг ханган биелүүлж, үргэлжлүүлэн алдаа дутагдалгүй ажиллаж байгаа,
3. Сувилахуйн боловсролын болон мэргэжлийн мэдлэгээ ахлах зэрэг хамгаалах үеийн түвшнээс ахиулсан үзүүлэлттэй байх,

4. Шинээр төгссөн сувилагч мэргэжилтнийг дагалдуулан сургаж, туршлагажуулсан байх
5. Сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр 2-оос доошгүй судалгаа хийж, сувилахуйн мэргэжлийн онол практикийн бага хурлаар хэлэлцүүлсэн байх туршлагажуулсан
6. Мэргэжлийн зэрэг горилж буй хүсэлтийг бичгээр МСН-ийн нэр дээр гаргах
7. Сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн буюу сувилахуйн албанаас дэмжсэн тодорхойлолт

## **В. Зөвлөх зэрэг горилогч**

1. Мэргэжлийн тэргүүлэх зэрэг бүхий,
2. Мэргэжлийн тэргүүлэх зэргийн тусгай шалгуур бүрийг ханган биелүүлж, үргэлжлүүлэн алдаа дутагдалгүй ажиллаж байгаа,
3. Докторантурын сургалтанд хамрагдсан байх
4. Багшлах эрхийн гэрчилгээтэй байх
5. Мэргэжлийн чиглэлээр гарын авлага гаргасан байх
6. Мэргэжлийн чиглэлээр олон улсын сургалтанд хамрагдсан байх
7. Мэргэжлийн чиглэлээр төсөл хэрэгжүүлсэн байх
8. Мэргэжлийн зэрэг горилж буй хүсэлтийг бичгээр МСН-ийн нэр дээр гаргах

## **2013 онд мэргэжлийн зэргийн шалгалтанд орох сувилагч ,сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн болон сувилахуйн албаны дарга нарын анхааралд:**

1. Сувилагч мэргэжлийн зэрэг горилох эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийтлэг болон тусгай шалгуурын дагуу бүрдүүлсэн материалыг тухайн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн болон сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, сувилахуйн албаны дарга нар 2013 оны 02 дугаар сарын 18-аас 02 дугаар сарын 28-ны өдрүүдэд Монголын Сувилагчдын Нийгэмлэгт ирүүлнэ үү.

2. Монголын Сувилагчдын нийгэмлэгийн байр: Улсын хоёрдугаар төв эмнэлэг, 50 ортын I давхарт, МСН-ийн хариуцлагатай нарийн бичиг Р.Тогтох, харилцах утас 95726372, 93146072